

MICC ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2014 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 22 (6)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Peabody Energy болон Anglo American компаниуд PCI нүүрсний нэг тоннын FOB үнэ 116 ам.доллар байхаар Өмнөд солонгосын гангийн POSCO компанитай тохиролцжээ. 2014 оны эхний улиралд дэлхийн зах зээл дэх PCI нүүрсний үнэ өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын үнээс 4,5 ам.доллараар буурч байна.
- Петро Матад хувьцааны үнэ 172 хувиар өсөв. Петро Матад хувьцааны үнэ 12 сарын 31-ээс хойш 172 хувь өсчээ, тэр дундаа өнгөрсөн долоо хоногт 107 хувиар огцом өсчээ.
- Өнгөрсөн 2013 оны байдлаар Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2012 оныхтой харьцуулахад 4.5 хувиар буурч, 10.6 тэрбум ам долларт хүрчээ. тодруулбал экспорт болон импорт хоеулаа буурсан үзүүлэлттэй гарсан байна.
- Оюу Толгой компанийн баяжуулах үйлдвэрийн металл авалтын үзүүлэлт нэмэгдэж байгааг тус компанийн захирал мэдэгджээ. Оюу Толгойн металл авалтын түвшин өнгөрсөн оны 3 улиралд зэсээр 81.7 хувь, алт 66.3 хувь, мөнгө 54.9 хувь байсан бол дөрөвдүгээр улиралд бүгд өссөн үзүүлэлттэй байна.
- Монгол улсаас БНХАУ-руу түүхий газрын тос дамжуулах хоолой тавихаар болсон. Газрын тосны экспортлөч компаниудаас энэхүү саналыг Газрын тосны газар, Уул уурхайн яаманд тавьжээ.
- Эрдэс баялгийн салбарын өрсөлдөх чадвар, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх зорилго бүхий "Эрдэс баялаг 2025" олон нийтийн хэлэлцүүлэг эхэллээ.
- Оросын нүүрсний экспорт нэмэгджээ. 12.6 хувиар өсч 117,83 сая тоннд хүрчээ.

Харанга Ресурс компани ашиглалтын өмнөх гэрээ байгуулжээ

Сэлэнгэ аймагт төмрийн хүдрийн Сэлэнгэ төсөл хэрэгжүүлж буй "Харанга Ресурс" компани Ашигт малтмалын газартай уг төсөлд холбогдох Ашиглалтын өмнөх гэрээ байгуулжээ.

Энэхүү гэрээнд тус компани уурхайн ТЭЗҮ болон төлөвлөлтийг боловсруулж өргөн барих, уурхай байгуулах зэрэг асуудлууд тусгагджээ.

Одоогоор Сэлэнгэ төмрийн хүдэр төслийн ордод 17.2 хувийн төмрийн агуулга бүхий 254 сая тонн хүдрийн ЖОРК нөөц байгааг тогтоожээ. Мөн уг төслийн хүйтэн гол хэсгээс нэмж 50-100 сая тонн хүдрийн нөөцийг илрүүлэх боломжтой хэмээн тооцоолж байна.

"Харанга ресурс" компани нь анх 2010 онд Австралийн хөрөнгийн бирж дээр IPO гаргасан ба нэгж хувьцаа 0.20 австрали доллараар үнэлэгдэн гарсан. Монгол улсад төмрийн хүдрийн 5 том төсөл хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Сэлэнгэ төсөл нь нийт төслийн 60 хувийг эзэлдэг томоохон төсөл юм. Улаанбаатар хотоос 200 км-т орших төмрийн хүдрийн гол бүс нутагт байрладаг.

"Харанга Ресурс" нийт 241.7 сая ширхэг хувьцаа гаргасан ба зах зээлийн нийт үнэлгээ 19.34 сая австрали доллар.

Өнөөдрийн байдлаар хувьцааны үнэ 0.80 австрали доллар байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА



"АЛТАН РИО МИНЕРАЛС" КОМПАНИ ЕСБХБ-С 10 САЯ АМ ДОЛЛАРЫН САНХҮҮЖИЛТ АВЧЭЭ

2014.01.08-ний өдөр Алтан Рио Минералс компани мэдэгдэл хийсэн ба ЕСБХБ-аас компанийн Монголд явуулж буй үйл ажиллагааг дэмжих зорилготойгоор 10 сая ам долларын санхүүжилт олгохыг зөвшөөрчээ. ЕСБХБ нь нийт 61 хувь эзэмшигчидтэй, үүнээс 59-засгийн газрийн, 2 -олон улсын байгууллага байдаг ба Төв Европоос Төв Ази хүртэл нийт 29 оронд хөрөнгө оруулалт хийдэг.

ЕСБХБ нь компанийн 1,600,000 ширхэг хувьцааг нэгж бүрыг нь 0.06 канад доллараар үнэлж худалдан авахыг зөвшөөрчээ.

Гэрээнд зааснаар компани гаргасан бизнес-төлөвлөгөөнийхөө дагуу Монголд хайгуулын үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах ба улирал бүр хийж буй үйл ажиллагааныхаа үр дүнг ЕСБХБ-д танилцуулж байх үүрэгтэй ба компанийн бизнест тодорхой хэмжээний өөрчлөлт гарах, бүтээн байгуулалт, компанийн дахин төлөвлөлт зэрэгт өөрчлөлт гарах мөн хувьцаан дахь гадаад санхүүжилттай холбоотой асуудлуудад ЕСБХБ-аас харилцан зөвшөөрөл авч ажиллана хэмээн тохиролцжээ. Эхний зурсан гэрээнээс олсон орлого болох ойролцоогоор 1,000,000 ам долларыг Компанийн хайгуулийн ажлыг урагшлуулах мөн эргэлтийн хөрөнгийг сайжруулахад хэрэглэх юм.

ШАРЫН ГОЛЫН УУРХАЙН НҮҮРСЭЭР УТААГҮЙ ШАХМАЛ ТҮЛШ ҮЙЛДВЭРЛЭНЭ.

"Шарын гол" ХК-ийн удирдлага нүүрс баяжуулах үйлдвэр барих, утаагүй түлш-брикетийн үйлдвэрээ өргөтгөх ажилд зориулан ЕСБХБ-аас 10 сая ам долларын санхүүгийн багц зээл авах гэрээнд гарын үсэг зурсан байна. Тус зээлээр байгалийн болон механик чулуу хольцыг ялгах, ангижруулж боловсруулах үйлдвэр барьж мөн шахмал түлшний үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх боломж бий болох юм.

Угаасан нүүрс болон брикетэн түлш нь үйлдвэрээс эцсийн хэрэглэгчдэд буюу хайлуулах, цементийн үйлдвэрүүд болон айл өрхийн хэрэгцээнд очих юм.

Удаанхугацааны зээлийн санхүүжилт нь "Шарын гол" ХК-д өөрийн охин компани болох Нако түлш ХК-аар дамжуулан Монгол улсын зах зээлд нийлүүлэх утаагүй түлшээ үйлдвэрлэн гаргах төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн гаргах боломж олгож байна. Уг бүтээгдэхүүн нь 2015 оны өвөл гэхэд Улаанбаатар хотын агаарын чанарыг бодитойгоор сайжруулна гэсэн төлөвлөгөөтэйгөөр гарч байгаа юм.



THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER
PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT CORPORATION IN MONGOLIA.

MICC хөрөнгө оруулалтын корпорацийн тухай

MICC нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа,
судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг

MICC ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин
танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх
боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны ЭРСДЭЛ таны ХАРИУЦЛАГА.

Эрхлэгч: Э. Оюу.

2013/01/22

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж, MSCI Barra,
OECD.